

Хэлэлцүүлэгт зориулсан танилцуулга

МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ТОЙМ ДҮГНЭЛТ

Боловсруулсан: П.Хишигбаяр

Хянан тохиолдуулсан: Д.Оюунбадам /Ph.D/

2016 оны 10-р сар

ТАЙЛАНГИЙН ЗОРИЛГО, АГУУЛГА

Засгийн газраас УИХ-д өргөн барьсан Монгол Улсын 2017 оны төсөвт орлого төлөвлөлтийн талаас тойм дүгнэлт хийж, төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр бодлогын зөвлөмж боловсруулах, төсвийн мэдээллийг бодлого боловсруулагчид болон иргэд, олон нийтэд хүртээмжтэй, шинжилгээ, дүгнэлт бүхий хэлбэрээр танилцуулахад оршино.

	ТОЙМ ДҮГНЭЛТҮҮД	ХУУДАС
	ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЧИГ ХАНДЛАГА	3
	МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ШИНЖИЛГЭЭ	11
	ТӨСВИЙН ОРЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ	20
	ХАВСРАЛТ № 1	26


ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Түүхий эдийн зах зээлийн чиг хандлага

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ ТОДОРХОЙГҮЙ ХЭВЭЭР ХАДГАЛАГДАХ БА САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ӨӨДРӨГ БУС ХАНДЛАГА ҮРГЭЛЖЛЭХ ТӨЛӨВТЭЙ...


Дэлхийн эдийн засгийн төлөв, таамаглал

Дэлхийн бодит эдийн засгийн өсөлт 2017 он (%)



Сангийн бодлого

2016 оны 10-р сарын
ТӨСВИЙН ТЭНЦЭЛ %



ТОЙМ ДҮГНЭЛТ

Олон Улсын Валютын Сангаас 2016 оны 10-р сард гаргасан таамаглалд 2017 онд дэлхийн эдийн засгийн өсөлт 2016 онтой харьцуулахад хэвийн, бага зэргийн өсөлттэй буюу голч 3.4% байхаар тооцоологдсон. Энэ нь 2016 оны 4-р сард таамаглаж байснаас 0.1%-ийн бууралттай байна. Тус бууралтын голлох шалтгаан нь Их Британи Европын холбооноос гарах шийдвэр, БНХАУ-ын эдийн засгийн сааралт, улс орнуудын улс төрийн тодорхойгүй байдлаас тус тус шалтгаалсан байна.


① **Мөнгөний зөөлөн бодлогоор эдийн засгийн өсөлтийг тэтгэж чадахгүй:** Хөгжингүй орнуудын төв банкууд сүүлийн жилүүдэд мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлэх замаар эдийн засгийг урамшуулах бодлого барьж байсан. Гэвч ирэх жилүүдэд энэ бодлого хадгалагдах боломж тун хомс байна. Учир нь төв банкууд Засгийн газрын бондын 30 гаруй хувийг аль хэдийн худалдан аваад байгаа ба Японы төв банкны хувьд 40 хувьд хүрээд байна.

② **Хялбар мөнгө дууссан буюу бага өгөөж:** Дэлхийн зах зээлийн тодорхойгүй, өндөр хэлбэлзэлтэй нөхцөл байдал, төв банкуудын зөөлөн мөнгөний бодлого явуулах боломжийн хомсдол, ханшийн хэлбэлзэл зэргээс шалтгаалан хөрөнгө оруулагчид найдвартай урт хугацаат бага хүүтэй хөрөнгө оруулалтын хэрэгслийг түгээмэл сонгох болсон.

③ **БНХАУ-ын эдийн засаг таамаглаж байснаас саарах:** 20 гаруй жил тогтвортой 10%-иас дээш өсөлттэй байсан БНХАУ-ын хувьд сүүлийн жилүүдэд өсөлт нь саарч 7%-д хүрсэн. Энэ өсөлт цаашид тогтворжихгүй ирэх жилүүдэд улам бүр буурах эрсдэлтэй болсон ба 2017 онд 6%-иас буурах, 2018 онд 4.2% хүрч буурах хандлага ажиглагдаж байна.

ДЭЛХИЙН АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ ӨМНӨХ ХОЁР
ЖИЛИЙН ТҮВШИНДӨӨ ХАДГАЛАГДСАН ХЭВЭЭР БАЙНА. . .

		2015												2016										
		Nov	Dec	Jan	Feb	Mar	Apr	May	Jun	Jul	Aug	Sep	Oct	Nov	Dec	Jan	Feb	Mar	Apr	May	Jun	Jul	Aug	Sep
Хөгжингүй орнууд	Дэлхий	51.7	51.4	51.6	51.8	51.5	50.8	51.0	50.9	50.8	50.5	50.4	51.1	51.0	50.7	50.9	50.0	50.6	50.2	50.0	50.4	51.0	50.8	51.0
	АНУ	54.8	53.9	53.9	55.1	55.7	54.1	54.0	53.6	53.8	53.0	53.1	54.1	52.8	51.2	52.4	51.3	51.5	50.8	50.7	51.3	52.9	52.0	51.5
	Евро бүс	50.1	50.6	51.0	51.0	52.2	52.0	52.2	52.5	52.4	52.3	52.0	52.3	52.8	53.2	52.3	51.2	51.6	51.7	51.5	52.8	52.0	51.7	52.6
	Герман	49.5	51.2	50.9	51.1	52.8	52.1	51.1	51.9	51.8	53.3	52.3	52.1	52.9	53.2	52.3	50.5	50.7	51.8	52.1	54.5	53.8	53.6	54.3
	Франц	48.4	47.5	49.2	47.6	48.8	48.0	49.4	50.7	49.6	48.3	50.6	50.6	50.6	51.4	50.0	50.2	49.6	48.0	48.4	48.3	48.6	48.3	49.7
	Итали	49.0	48.4	49.9	51.9	53.3	53.8	54.8	54.1	55.3	53.8	52.7	54.1	54.9	55.6	53.2	52.2	53.5	53.9	52.4	53.5	51.2	49.8	51.0
	Испани	54.7	53.8	54.7	54.2	54.3	54.2	55.8	54.5	53.6	53.2	51.7	51.3	53.1	53.0	55.4	54.1	53.4	53.5	51.8	52.2	51.0	51.0	52.3
	Грек	49.1	49.4	48.3	48.4	48.9	46.5	48.0	46.9	30.2	39.1	43.3	47.3	48.1	50.2	50.0	48.4	49.0	49.7	48.4	50.4	48.7	50.4	49.2
	Их Британи	53.1	52.6	52.9	54.1	53.7	52.2	52.0	51.2	52.3	51.7	51.5	55.1	52.3	51.7	53.0	50.8	51.0	49.5	50.4	52.1	48.2	53.4	55.4
	Австрали	50.1	46.9	49.0	45.4	46.3	48.0	52.3	44.2	50.4	51.7	52.1	50.2	52.5	51.9	51.5	53.5	58.1	53.4	51.0	51.8	56.4	46.9	49.8
Япон	52.0	52.0	52.2	51.6	50.3	49.9	50.9	50.1	51.2	51.7	51.0	52.4	52.6	52.6	52.3	50.1	49.1	48.2	47.7	48.1	49.3	49.5	50.4	
Хөгжиж буй орнууд	БНХАУ	50.6	50.4	50.8	50.9	49.8	49.3	49.4	49.2	48.8	48.3	48.3	48.9	49.0	49.2	49.2	48.8	50.0	49.5	49.5	49.3	50.1	49.8	50.1
	БНХАУ (ҮСХ)	50.0	49.6	49.7	50.7	49.6	48.9	49.2	49.4	47.8	47.3	47.2	48.3	48.6	48.2	48.4	48.0	49.7	49.4	49.2	48.6	50.6	50.0	50.1
	Индонези	48.0	47.6	48.5	47.5	46.4	46.7	47.1	47.8	47.3	48.4	47.4	47.8	46.9	47.8	48.9	48.7	50.6	50.9	50.6	51.9	48.4	50.4	50.9
	Ө.Солонгос	49.0	49.9	51.1	51.1	49.2	48.8	47.8	46.1	47.6	47.9	49.2	49.1	49.1	50.7	49.5	48.7	49.5	50.0	50.1	50.5	50.1	48.6	47.6
	Тайван	51.4	50.0	51.7	52.1	51.0	49.2	49.3	46.3	47.1	46.1	46.9	47.8	49.5	51.7	50.6	49.4	51.1	49.7	48.5	50.5	51.0	51.8	52.2
	Энэтхэг	53.3	54.5	52.9	51.2	52.1	51.3	52.6	51.3	52.7	52.3	51.2	50.7	50.3	49.1	51.1	51.1	52.4	50.5	50.7	51.7	51.8	52.6	52.1
	Бразил	48.7	50.2	50.7	49.6	46.2	46.0	45.9	46.5	47.2	45.8	47.0	44.1	43.8	45.6	47.4	44.5	46.0	42.6	41.6	43.2	46.0	45.7	46.0
	Мексик	54.3	55.3	56.6	54.4	53.8	53.8	53.3	52.0	52.9	52.4	52.1	53.0	53.0	52.4	52.2	53.1	53.2	52.4	53.6	51.1	50.6	50.9	52.2



Эх сурвалж: Goldman Sachs, FactSet, Markit, J.P. Morgan Asset Management Зах Зээлийн Хөтөч судалгаа-2016Q4, Судалгааны багийн дүн шинжилгээ . The Global Purchasing Managers' Index (PMI) индекс нь аж үйлдвэрийн салбарын эдийн засгийн эрүүл байдлыг харуулдаг чухал индекс юм. Дэлхийн PMI –г тооцохдоо ДНБ-ны жигнэсэн дунджаар дүйцүүлсэн болно. БНХАУ(ҮСХ) үзүүлэлтийг БНХАУ Үндэсний статистикийн хорооноос эрхлэн гаргадаг, Бүх тоон мэдээ 2016 оны 9-р сарын 31-ны байдлаар

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛД БОГИНО ХУГАЦААНЫ СЭРГЭЛТ АЖИГЛАГДАЖ
БАЙГАА Ч ЦААШДЫН ТӨЛӨВ ТОДОРХОЙГҮЙ ХЭВЭЭР БАЙНА...

ТООЦООЛОЛ


Суурь металл, төмрийн хүдрийн үнийн индекс

US\$ индекс, 2010=100



Эрчим хүч, Хөдөө аж ахуйн таваарын индекс

US\$ индекс, 2010=100



Эх үүсвэр: Дэлхийн банк, Түүхий эдийн зах зээлийн төлөв тайлан 2016 10-р сар,
Wood Mac, Credit Suisse Global Connection Series Commodities Forecast

ТОЙМ ДҮГНЭЛТ

1 2007 – 2009 оны Дэлхийн санхүүгийн хямрал (ДСХ) –ын дараа эрдэс бүтээгдэхүүн, уул уурхайн түүхий эдийн үнэ огцом сэргэсэн боловч Европын өрийн хямрал болон ОУ-ын зөрчилдөөнт нөхцөл байдлуудын улмаас дахин унаж 2009 оны үетэй ижил түвшинд хүрээд байна.

Суурь металл болон төмрийн хүдрийн индексжүүлсэн үнийн хувьд 5 жил дараалан харгалзан 49 р.р болон 70 р.р нэгжээр тус тус буурсан бол Хөдөө аж ахуй, металл ,эрчим хүчний түүхий эдийн үнийн хувьд мөн 5 жил дараалан буюу 46.6 р.р, 69.1 р.р, 80.3 р.р тус тус буурсан.


2 2016 он гарсаар 3 улирал дараалан түүхий эдийн зах зээл өссөн. 3-р улирлыг Эрчим хүчний индексийн хувьд 2016 оны 2-р улиралтай харьцуулахад 3%-иар өссөн бол БНХАУ-д нүүрсний үнэ он гарсаар 30%-иар өсөөд байна. Энэ нь БНХАУ зүгээс жижиг нүүрсний уурхайг хаах, дотоодын нүүрсний олборлолтыг бууруулах чиглэлд бодлого барьж буйтай холбоотой юм.

Гэвч эдгээр өсөлтийг цаашид тогтвортой хадгалагдах магадлал муутай гэж Дэлхийн банкны шинжээчид үзэж байна. Ялангуяа төмрийн хүдрийн хувьд 2009 оны үнийн хямралын индексээс доогуур түвшинд орсон ба 2020 он хүртэл нөхцөл байдал сайжрахгүй гэж дүгнэсэн.

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨӨРЧЛӨЛТ, ЧИГ ХАНДЛАГА (2016 – 2020)


Зах зээлийн өөрчлөлт, чиг хандлага

Үнэ/Үйлдвэрлэлийн өсөлтийн харьцаа (%)



Голлох түүхий эдийн үнийн таамаглал

Бодит индексжүүлсэн үнэ (2009=100%)



Эх үүсвэр: Дэлхийн банк, Түүхий эдийн зах зээлийн төлөв тайлан 2016 10-р сар,
Wood Mac, Credit Suisse Global Connection Series Commodities Forecast

ТОЙМ ДҮГНЭЛТ


Түүхий эдийн зах зээлд гарч буй динамик өөрчлөлтийг харахад 2009 – 2016 оны хооронд үнийн өндөр хэлбэлзэлтэй (дунджаар -50%-с +50%) байсан нь ажиглагдаж байна. Ялангуяа 2011 оноос эхлэн түүхий эдийн үнэ хурдтай буурч эхэлсэн байна.

Харин 2016- 2020 оны зах зээлийн өөрчлөлтийг харахад үйлдвэрлэлийн өсөлтөд ихээхэн хэлбэлзэл ажиглагдах төлөвтэй. Учир нь түүхий эдийн эрэлт сул байгаа тул үнийн өсөлт ажиглагдахгүй болж ихэнх уурхайнууд үйлдвэрлэлийн өсөлтөөр зах зээлээ хадгалж үлдэхийг чармайж байна. Тухайлбал төмрийн хүдэр болон коксжих нүүрсний үнэ 20% хүртэл буурсан ч үйлдвэрлэлийн хэмжээ 20%-40% нэмэгдүүлсээр байна. Энэхүү нөхцөл байдлыг Wood Mac-ийн зүгээс over supply буюу илүүдэл нийлүүлэлтийн үе гэж нэрлэж байна.


Илүүдэл нийлүүлэлт хадгалагдаж байгаа үед ихэнх уул уурхайн компаниуд шинээр хөрөнгө оруулалт хийхээ азнаж, зардал бууруулах, өрийн санхүүжилтийн хэмжээгээ багасгахаар ажиллаж байна.

БНХАУ-ЫН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БҮТЦИЙН ШИЛЖИЛТИЙН “ШИНЭ ХЭВИЙН” БОДЛОГО

Голлох макро эдийн засгийн үзүүлэлтүүд



Үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалт¹



ТОЙМ ДҮГНЭЛТ

БНХАУ-ын бодлого боловсруулагчид үл хөдлөх хөрөнгийн болон экспортын өсөлтөд суурилсан эдийн засгийн хөгжлийн загвараас дотоодын хэрэглээнд суурилсан, өндөр технологийн эдийн засагт шилжих бүтцийн шилжилтийн бодлогыг 2012 оноос албан ёсоор зарлан хэрэгжүүлж эхлээд байна. Тус бодлогыг “Шинэ Хэвийн” тэнцвэртэй өсөлтийн загвар гэж нэрлэж байна.

Дээрх бодлогыг хэрэгжүүлж эхэлснээр байгаль орчинд халтай үйлдвэрлэлийг эрс бууруулах, хүчин чадал нь хэтэрсэн салбарууд (цемент, ган, эрчим хүчний болон коксжих нүүрс г.м)-ад хөрөнгө оруулалтыг бууруулж, хүчин чадал бага, жижиг уурхайнуудыг хааж эхэлсэн. Энэ нь ялангуяа хүнд аж үйлдвэрлэл өндөр хөгжсөн далайн эргийн мужуудын үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж эхэлсэн.

Хувийн хэрэглээнээс бусад макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн өсөлт сүүлийн 4 жил дараалан саарсан. 2017 оны хувьд ДНБ өсөлт 6%-иас буурахаар хүлээгдэж байна. Гадаад худалдааны эргэлт 2015 оноос эхлэн буурч буй нь сүүлийн 20 жилд анх удаа болж буй тохиолдол юм.

2008 оноос хойш үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтын жилийн өсөлт аажим буурч 8%-д хүрээд байна. Энэ нь 2001 оноос хойших хамгийн бага өсөлтийн хувь юм. Хот руу шилжих хөдөлгөөн нэмэгдэж, хөдөлмөрийн зардал хурдтай өсч, ханшийн дарамт нэмэгдэж буй зэрэг сөрөг хандлага нь тус улсын эдийн засагт дарамтыг бий болгож байна.

Экономист сэтгүүлийн EIU²-аас 2016 оны 10-р сарын 19-нд гаргасан “БНХАУ-н төлөв тайлан”-д дурдсанаар тус улсын эдийн засгийн сааралт цаашид улам бүр гүнзгийрч, түүхий эдийн зах зээлд уналт бий болж 2018 онд хатуу газардах бөгөөд сөрөг нөлөөлөл нь Австрали, Чили, Монгол зэрэг улс орнуудад хүчтэй тусна гэж үзжээ.


Эх сурвалж: БНХАУ Үндэсний Статистикийн Хороо, The Beijing Axis, Bloomberg, The Brookings Institution, EIU, OYBC

1 Fixed Asset Investment , 2 Economist Intelligence unit

БНХАУ-ЫН БАЙГУУЛЛАГЫН ӨРИЙН АСУУДАЛ АНХААРАЛ ТАТАЖ БАЙНА...


Өрийн түвшин болон Эдийн засгийн өсөлтийн харьцаа

(2005 – 2015) \$/(%)



БНХАУ-ын ДНБ-д эзлэх нийт өр

ДНБ эзлэх хувь (%), бусад улс оронтой харьцуулсан



Эх сурвалж: Mckinsey Global Institute, Bloomberg, BlackRock Investment Institute, Монгол улсын сангийн яам

ТОЙМ ДҮГНЭЛТ

2015 оны жилийн эцсийн байдлаар БНХАУ-ын ДНБ-ий хэмжээ ~10.9 их наяд ам.долларт хүрч дэлхийн 2-догч том эдийн засаг болсон. 1990 онд дэлхийн эдийн засгийн ердөө 2%-г бүрдүүлж байсан тус улс 2015 оны байдлаар 15%-г дангаараа бүрдүүлж буй нь 1992 – 2010 оны хооронд жил бүр дунджаар 10%-иар тогтмол өсөж байсантай холбоотой.

Эдийн засгийн хурдтай өсөлтийг тогтвортой хадгалах, аж үйлдвэржилтийг дэмжих санхүүгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлэх хүрээнд БНХАУ нь өрийн хэмжээг сүүлийн жилүүдэд асар хурдтай нэмэгдүүлж 2015 оны байдлаар нийт ДНБ-тай харьцуулсан өрийн хэмжээ 280% хүрсэн. Энэ нь бусад хөгжингүй улс орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байгаа нь анхаарал татаж байна.


Гэвч сүүлийн жилүүдэд (2010 – 2015) тус улсын ДНБ-ий өсөлт аажмаар буурч 10.4%-иас 6.8%-д хүрээд байна. Эдийн засгийн өсөлт саарч, өрийн хэмжээ нэмэгдэх болсон нь БНХАУ-д өрийн хямрал тулгарч болзошгүй эрсдэлийг нэмэгдүүлж байна. ОУВС, БлэкРок Хөрөнгө оруулалтын Институт, EIU, Блүүмберг зэрэг томоохон байгууллагуудын зүгээс 2017 онд тус улсад хямрал болох эрсдэлтэйг анхааруулсаар байна.

Ялангуяа нийт өрийн хэмжээнд эзэлж буй байгууллагын өрийн түвшин хурдтай нэмэгдэж буй ба 2000 онд ДНБ-ны 83%-тай тэнцэж байсан бол 2015 онд 125% болж өссөн. Байгууллагын өрийн ихэнх хэсэг буюу 55%-ийг төрийн өмчит томоохон компаниудын өр эзэлж байгаа эдийн засгийн өсөлт саарахын хэрээр тэдгээр компаниудын борлуулалт буурч өрийг дахин санхүүжүүлэх эрсдэл тулгарч байна.

Гэхдээ БНХАУ-г өрийн хямралд орох эрсдэлийг бууруулж буй хүчин зүйл нь тус улсын өрхийн өрийн хэмжээ харьцангуй бага, иргэдийн хадгаламж харьцангуй их байгаа явдал юм.

БНХАУ –Д ГАРЧ БУЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ӨӨРЧЛӨЛТ НЬ МОНГОЛ УЛСЫГ ЦААШИД
ЭКСПОРТЫН СТРАТЕГИЙГ НУХАЦТАЙ АВЧ ҮЗЭХ БОДИТ ШААРДЛАГА ҮҮСГЭЖ БАЙНА.

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТ /2010-2015 он/



ХЯТАДЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨӨРЧЛӨЛТ /2010 - 2015 он/



ТОЙМ ДҮГНЭЛТ

- Дэлхийн голлох эдийн засгууд хямралт нөхцөл байдалтай байгаа учраас эдийн засгийн өсөлтийн хурд нь удааширч, улмаар үйлдвэрлэлийн үндсэн түүхий эдийн хэрэглээ буурч байна. Энэ хандлага нь олон улсын зах зээл дээрх түүхий эдийн эрэлтэд сөргөөр нөлөөлж богино, дунд хугацаанд хэвээр хадгалагдахаар байна.
- Сүүлийн жилүүдэд хамгийн эрчтэй хөгжиж буй технологийн салбарын хөгжил нь тус салбарын түүхий эд, бүтээгдэхүүний өртгийг хямдруулахад хүргэж байна.
- Хэдий технологийн өртөг хурдтай буурсан ч хүмүүн капитал буюу хөдөлмөрийн зардал улс орон бүрт хурдацтай өсөж байна. Ялангуяа БНХАУ-д цалингийн зардлын өсөлт сүүлийн 5 жилд дунджаар 54%-иар нэмэгдсэн.
- БНХАУ-ын хувьд сүүлийн жилүүдэд эдийн засаг нь тогтмол 10 гаруй хувиар өсөж, өндөр технологи шаарддаггүй үйлдвэрлэл, дэд бүтцийн салбарын хөгжлөөр хамгийн өндөр түвшинд хүрсэн. БНХАУ-ын Коммунист намаас Хятад улсын үйлдвэрлэлийн салбарын өрсөлдөх чадварыг сайжруулах “Made in China-2025” хөтөлбөрийг хэрэгжүүлж үйлдвэрлэлийн чадлын хэтрэлт бүхий кластерууд, дэд бүтэц болон бодлогын дэмжлэгийг ашиглан R&D, инноваци, өндөр технологи, хүний хөгжлийн асуудалд илүүтэй анхаарч эхэлсэн.
- Энэ нь тус улсын үйлдвэрлэлийн үндсэн түүхий эдийг бэлтгэн нийлүүлэгч Монгол улсын хувьд ирээдүйн уул уурхайн салбараас хүлээх орлогыг өөдрөг төсөөлөх боломжийг бууруулж байна. Иймээс цаашид экспортын стратегийг нухацтай авч үзэх бодит шаардлага үүсч байна.


МОНГОЛ УЛСЫН 2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ШИНЖИЛГЭЭ

ТОЙМ ДҮГНЭЛТ, НАРИЙВЧИЛСАН ШИНЖИЛГЭЭ

2017 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО 6.19 ИХ НАЯД ТӨГРӨГ БУЮУ 2016 ОНЫ ТОДОТГОЛТОЙ (ЦААШИД ТОД) ХАРЬЦУУЛАХАД 15.8%-ИАР ӨСӨХӨӨР, 2016 ОНЫ БАТАЛСАН ТӨСӨВТЭЙ ХАРЬЦУУЛАХАД 11.8%-ИАР БУУРАХААР ТӨЛӨВЛӨГДСӨН.

Нэгдсэн Төсвийн орлого, бүтэц

Их Наяд төгрөг



Эх үүсвэр: Судлаачийн тооцоо, Сангийн яам.

Тойм дүгнэлт

- 2017 оны Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогыг **~6.19** их наяд төгрөг буюу 2016 оны тодотголтой (цаашид Тод) харьцуулахад 15.8%-иар буюу **~0.85** их наяд төгрөгөөр өсөхөөр, 2016 оны баталсан төсөвтэй харьцуулахад 11.8%-иар буюу **~0.83** их наяд төгрөгөөр буурахаар тооцсон.
- Нэрлэсэн ДНБ-ийг **~26.18** их наяд төгрөгт хүрч 2016 оны тодотголоос 8.2%-иар өсөхөөр төсөөлсөн. Нэгдсэн төсвийн нийт орлогын нэрлэсэн ДНБ-нд эзлэх хувь хэмжээг 23.66% байхаар тооцсон.
- Төсвийн тогтворжуулалтын санд **~12.49** тэрбум төгрөг хуримтлуулахаар төлөвлөсөн буюу 2016 оны баталсан төсвөөс 48%-иар нэмэгдэхээр байна.
- 2017 оны 1-р сарын 1-нээс хэрэгжиж эхлэх Ирээдүйн өв санд **~208.12** тэрбум төгрөг төвлөрөхөөр төсөөлсөн.
- Нийт төсвийн орлогын 82% буюу **~4.9** их наяд төгрөгийг татварын орлогоос, 18% буюу **~1.06** их наяд төгрөгийг татварын бус орлогоос тус тус бүрдүүлэхээр тооцсон.
- 1993 оноос хойш анх удаа Монгол улсын нэгдсэн төсвийн орлого дараалан 2 жил бууралттай (2014-2016) гарч байна. Энэ нь татварын орлого төрөлжөөгүй, уул уурхайн салбараас хамааралтай, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалд улам бүр тод мэдрэгдэж байна.

2017 ОНЫ ОРЛОГЫН ТӨСӨЛ НЬ 2016 БОЛОН 2013 -15 ОНЫ ДУНДАЖ ТАТВАРЫН ОРЛОГОТОЙ ХАРЬЦУУЛАХАД УУЛ УУРХАЙН ОРЛОГЫГ БУУРУУЛЖ, ТАТВАРЫН БУС ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛСЭН.

Тооцоолол

(Тэрбум Төгрөг)	2013–15 Дундаж	Δ2017/(2013–15)	Δ2017/(2013–15)%	2016 Тод	Δ2017/2016	Δ2017/2016%	2017 Төс
Татварын орлого	5,116	-211	-4%	4,511	+395	+9%	4,906
Орлогын албан татвар	1,127	-72	-6%	952	+103	+11%	1,055
ХХОАТ	486	+70	+14%	518	+37	+7%	555
ААНОАТ	657	-157	-24%	434	+66	+15%	500
НДШ, хураамж	937	+227	+24%	1,055	+108	+10%	1,163
Хөрөнгийн татвар	60	+4	+6%	56	+8	+14%	64
НӨАТ	1,285	-47	-4%	1,081	+157	+14%	1,238
НӨАТ-ын буцаан олголт	(93)	-77	-82%		-68	-67%	
Онцгой албан татвар	499	+49	+10%	532	+15	+3%	547
Тусгай зориулалтын орлого	29	+15	+50%	42	+2	+5%	44
Гаалийн албан татвар	352	+28	+8%	302	+78	+26%	380
Бусад татвар (төлбөр, хураамж)	826	-412	-50%	489	-75	-15%	414
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	448	-340	-76%	255	-147	-58%	108
Ө.НАМ нөөц ашигласны төлбөр	100	-100	-100%	-			-
Нийслэл хотын албан татвар	-	+20		10	+10	+100%	20
Татварын бус орлого	950	+120	+13%	838	+232	+28%	1,069
Нийтлэг бус татварын орлого	903	-96	-11%	724	+83	+11%	807
Хувьцааны ногдол ашиг	48	-38		12	-2	-15%	11
Хөрөнгийн орлого	29	+99	+341%	2	+126	+7892%	128
Өмч хувьчлалын орлого	27	+101	+376%	1	+126	+13691%	127
Тусламжийн орлого	18	+117	+655%	112	+22	+20%	135
Хандив тусламж /гадаад/	18	+117		112	+22	+20%	135

■ Абсолют Өсөлт (Тэрбум Төгрөг)
■ Абсолют бууралт (Тэрбум Төгрөг)
■ Хувийн өсөлт (%)
■ Хувийн бууралт (%)

Сүүлийн 5 жилд нэгдсэн төсвийн нийт орлого жил бүр дунджаар ~1.1 их наяд төгрөгөөр тасардаг (өөдрөг төсөөлдөг^Б) ба голлох шалтгаан нь ААНОАТ НӨАТ, Гаалийн албан татвар, Өмч хувьчлалын орлогын дутуу гүйцэтгэлээс шалтгаалсан.

УИХ-р баталсан төсөв болон төсвийн гүйцэтгэл хоорондын тасалдлын хувь % ■ ≤ 0% ■ ≤ -10% ■ > -10% NA тухайн жил төсөвлөгдөөгүй

	Төсвийн жил ^А					Тэрбум ₮ Дундаж зөрүү ²
	2012	2013	2014	2015	2016ХБГ ¹	
ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН						(1,116.0)
Тогтворжуулалтын сан			4			(76.2)
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО&ТУСЛАМЖ						(1,108.9)
1.0 Татварын орлого						(964.0)
1.1 Орлогын албан татвар						(102.1)
Хувь хүний орлогын албан татвар					2	4.3
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар						(109.9)
1.2 Нийгмийн даатгалын орлого						(35.1)
1.3 Хөрөнгийн албан татвар						16.0
1.4 Нэмэгдсэн өртгийн албан татвар	1					(437.7)
Дотоодын барааны НӨАТ						(164.1)
1.5 Онцгой албан татвар						(63.3)
1.6 Тусгай зориулалтын орлого						(7.2)
1.7 Гадаад үйл ажиллагааны орлого	3					(140.9)
Импортын гаалийн албан татвар						(140.9)
1.8 Бусад татвар (Төлбөр, хураамж)						(193.7)
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр						(27.2)
Байгалийн нөөц ашигласны төлбөр						(7.3)
Бусад татвар						(117.2)
Өсөн нэмэгдэх а/малтмалын нөөц төлбөр					7 NA ³	(84.1)
2.0 Татварын бус орлого			4			(135.6)
Нийтлэг бус татварын орлого					6	(39.6)
Хувьцааны ногдол ашиг						(22.7)
2.1 Хөрөнгийн орлого	NA ³			5		(48.0)
Өмч хувьчлалын орлого	NA					(60.0)
2.2 Тусламжийн орлого	NA	NA	NA			(48.1)

 Орлогын тасалдлыг нэмэгдүүлсэн хүчин зүйл

 Орлогын тасалдлыг бууруулсан хүчин зүйл

Эх үүсвэр: Судлаачийн тооцоо,
Сангийн яам.

Б Жил бүр хэтрүүлдэг тул “төлөвлөх” гэх үгийн оронд “төсөөлөх” гэх үгийг ашигласан.

А Төсвийн жил гүйцэтгэлээр

1 ХБГ- Хүлээгдэж буй гүйцэтгэл. 2016 оны нэгдсэн төсвийн ХБГ тооцоолохдоо 2012-2015 онуудын эхний 9 сарын орлогын гүйцэтгэлд суурилан тооцсон.


2 Жил бүрийн дундаж биелээгүй гүйцэтгэлийн хэмжээ эсхүл өөдрөг төсөөллийн хэмжээ

3 Тухайн жилд тус татварыг төсөвлөөгүйг илтгэнэ.

ОРЛОГЫН ТАСАЛДЛЫН ~56% НЬ НӨАТ, ААНОАТ, ИМПОРТЫН ГААЛИЙН АЛБАН ТАТВАРЫН БУУРАЛТААС ШАЛТГААЛСАН БА ЭДГЭЭР ТАТВАРЫН БУУРАЛТ НЬ ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХ СААРСАНТАЙ ШУУД ХОЛБООТОЙ, ~36% НЬ БОДИТ БУС ТӨЛӨВЛӨДӨГТЭЙ ХОЛБООТОЙ.

Эдийн засгийн удаашралаас үүдсэн төсвийн орлогын тасалдал

ТООЦООЛОЛ



Эх үүсвэр: Судлаачийн тооцоо, Сангийн яам.

Тойм дүгнэлт

НӨАТ, ААНОАТ, Импортын гаалийн албан татвар нь сүүлийн 4 жилийн дунджаас үзэхэд нийт төсвийн орлогын 38%-г хамтдаа бүрдүүлдэг байна.







- НӨАТ-ын бууралт:** Нэгдсэн төсвийн голлох орлогуудын нэг НӨАТ нь сүүлийн 4 жилийн турш тасралтгүй буурсаар 2016 оны ХБГ-р ~1.08 их наяд хүрч буурахаар байна. 2012 оны гүйцэтгэлтэй харьцуулахад даруй ~215 тэрбумаар буюу 16.6%-р буурахаар хүлээгдэж байна.
- ААНОАТ-ын бууралт:** 2013 – 2015 онуудын нэгдсэн төсвийн гүйцэтгэлтэй харьцуулахад ААНОАТ орлого дунджаар ~220 тэрбум төгрөгөөр буурсан. Харин 2012 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 17.2%-иар буурах төлөвтэй.
- Гадаад үйл ажиллагааны орлогын татвар:** Импортын татвар нь НӨАТ –тай ижил сүүлийн 4 жил дараалан буурсан. Ялангуяа эдийн засгийн идэвхжил саарч, гадаад валютын ханш саарсан зэрэг нь татварын бууралтын голлох шалтгаан юм. 2012 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 7.7%-иар буурахаар хүлээгдэж байна.

2 Системийн хэвийн бус зээлийг тооцохдоо нийт зээлийн өрийн үлдэгдлээс системийн нийт хэвийн зээлийг хасах байдлаар тооцсон. Системийн хэвийн бус зээлийн үзүүлэлтүүдийг сонгосон шалтгаан нь ихэнх арилжааны банкууд зээл чанаргүйдэж эхэлмэгч зээлийн гэрээг өөрчлөх замаар зээлийг бүтцийг чанаргүй ангилалд оруулдаггүй. Тиймээс чанаргүй зээлийн хувиас илүү хэвийн бус зээлийн тооцоо илүү бодитой байдагтай холбоотой.

ЗАРЛАГЫН ӨСӨЛТӨД НИЙЦҮҮЛСЭН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ

Зарлагын өсөлтөд нийцүүлсэн орлого төлөвлөлтийн тасралт

ТООЦООЛОЛ



Эх үүсвэр: Судлаачийн тооцоо, Сангийн яам.

Эх үүсвэр: Судлаачийн тооцоо, Сангийн яам.

Тойм дүгнэлт

4 Сүүлийн 4 жилд нэгдсэн төсвийн орлого дунджаар 81%-ийн биелэлттэй байна¹. 2014 оны хувьд төсвийн орлогын гүйцэтгэл 96%-ийн биелэлттэй гарсан нь татварын орлогын өсөлттэй холбоогүй ба татварын бус орлогын хүү торгуулийн орлого, бусад орлогын огцом өсөлтөөс шалтгаалсан. Тус онд хүү торгуулийн орлого, бусад орлогоос нийт **~103.4** тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн боловч **~450.2** тэрбум төгрөгт хүрч **~346.8** тэрбум төгрөгөөр буюу 335%-р давж биелсэн.


5 Татварын орлого төрөлжөөгүйн улмаас 3Г орлогыг зохиомол өсгөх, зардалтай нийцүүлэх орон зайг өмч хувьчлалын орлого, гарын үсгийн төлбөр гэх мэт татварын бус орлогыг нэмэгдүүлнэ гэж төлөвлөдөг. 2014, 2015 онуудад харгалзан **~127**, **~171** тэрбум төгрөгийг өмч хувьчлалын орлогоос төвлөрнө гэж тооцсон ч биелээгүй. 2017 оны төсвийн төсөлд Төрийн банк, Хөрөнгийн бирж, Оргил Рашаан сувилал, МЦХ ХК г.м 6 аж ахуй нэгжийг хувьчилж **~127.3** тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тооцсон.

6 **Хувьцааны ногдол ашиг:** 2012 – 2014 онуудад жилд дунджаар **~96** тэрбум төгрөгийн ногдол ашгийг Эрдэнэт үйлдвэрээс төвлөрүүлдэг байсан бол сүүлийн 2 жил буюу 2015 болон 2016ХБГ онуудад харгалзан **~11**, **~10** тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, Эрдэнэт үйлдвэрийн ногдол ашгийн хэмжээ **~80** гаруй тэрбум төгрөгөөр буураад байна. Энэ нь нэг талаас сүүлийн 3 жилд зэсийн зах зээлийн үнэ 39%-р унасантай холбоотой. Нөгөө талаас тус үйлдвэрийн үйлдвэрлэлийн өртгийн өсөлт, дотоод бүтэц зохион байгуулалтын өсөлттэй холбоотой.

Сүүлийн 5 жилийн төсвийн орлогын төлөвлөлтөд огт биелдэггүй буюу зохиомол төсөөллийн татвараас жил бүр дунджаар ~420 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тусгаж байсан. Энэ нь төсвийн төлөвлөлт, судалгаа дутуу боловсрогдож байгаа харуулж байна. ТООЦООЛОЛ

Төлөвлөгдсөн ч огт биелээгүй(байх магадлалтай) орлого

Тэрбум төгрөг ₮



“Сангийн сайд Б.Чойжилсүрэн: “Стэнд бай” хөтөлбөрт хамрагдвал 2017 оны төсөвт тодотгол хийнэ ”

Эх үүсвэр: <http://itoim.mn/index.php/site/news/6842>

ТОЙМ ДҮГНЭЛТ

2011 – 2015 онуудын УИХ-аар батлагдсан төсвийн төслөөс харахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн (ТТБТХ) 6.1.2-рт заасан төсвийн алдагдлыг тухайн жилийн нэрлэсэн ДНБ 2%-иас хэтрүүлэхгүй хүрээнд ДНБ-ийг үндэслэлгүй өсөлттэй төсөөлөх эсхүл орлогын төлөвлөлтөө зарлагад нийцүүлэн зохиомол өсгөх аргуудыг хэрэглэсээр ирсэн. 2015–2017 оны төсвийн төсөлд ТТБТХ-н нэмэлт өөрчлөлт оруулан ДНБ-д харьцуулсан төсвийн алдагдлыг 2017 онд 9.9 хувиас, 2018 онд 7.5%-иас, 2019 онд 5.5%-иас тус тус хэтрүүлэхгүй байхаар¹ өөрчилсөн.

Орлогын төлөвлөлтийг зарлагад нийцүүлэн зохиомол өсгөдөг хэд хэдэн жишээг дурдвал:

-2012 онд Таван Толгой төслийг хэрэгжүүлэн урьдчилгаа ~496.4 тэрбум төгрөгийн гарын үсгийн төлбөрт,

-2013 онд бусад татвараас ~515.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тооцсон ч дээрх орлогууд огт биелээгүй. 2014-2015 онуудад уул уурхайн дэлхийн зах зээлийн үнийг өснө гэсэн зохиомол төсөөллөөр

-2014 онд ~162.3 тэрбум төгрөг, 2015 онд ~218 тэрбум төгрөгийг өсөн нэмэгдэх роялтийн татвараас төвлөрүүлэхээр тооцсон ч биелээгүй.

-2017 оны төсвийн төсөлд өсөн нэмэгдэх роялтийн татвараас ямар нэгэн орлого төвлөрөхгүй байхаар тусгасан нь өмнөх жилүүдийн алдааг давтаагүй сайн талтай.

2016 оны төсвийн төсөлд өмч хувьчлалын орлогоос ~170 тэрбум төгрөгийг, гадаад хандив тусламжаас ~368 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тооцсон нь 2016 оны эхний 9 сарын байдлаар ердөө 10%-ийн биелэлттэй байна. 2017 оны төсвийн төсөлд өмч хувьчлалаас ~127.3 тэрбум, гадаад хандив тусламжаар ~134 тэрбум төгрөг буюу нийт ~261 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцсон нь анхаарал татаж байна.

1 2015 оны 01 дүгээр сарын 20, 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар тус тус өөрчлөн найруулсан.


УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ТАТВАРЫН ОРЛОГО

ТООЦООЛОЛ

УУ-н татварууд, голлох экспортын бүтээгдэхүүнээр (Тэрбум ₮)

Орлогын Өөрчлөлт (-/+)

Биет хэмжээний Өөрчлөлт (-/+)



Сангийн яамны төсөөлөл

	Биет хэмжээ			Үнэ чиг хандлага		
	2016 Төс	2016 ХБГ	2017 Төс	Одоо	Богино	Дунд
Алт (тн)	24	15	15	1250 \$/y	↓	→
Нүүрс (Сая.тн)	19,500	22,387	23,000	63 \$/т	↑	→
Зэсийн баяжмал (Сая.тн)	1,362	1,682	1,500	4599 \$/т	→	↑
Цайрын баяжмал (Сая.тн)	95	105	80	2000 \$/т	↓	↓
Төмрийн хүдэр (Сая.тн)	5,000	6,274	6,000	50 \$/т	→	↓

ТОЙМ ДҮГНЭЛТ

- Төсвийн төсөлд УУ-н салбараас нийт **~1,004** тэрбум төгрөг буюу нэгдсэн төсвийн нийт орлогын 17%-г бүрдүүлж, 2016 оны төсвийн төсөлтэй харьцуулахад 11%-иар нэмэгдэхээр төсөөлсөн.
- Нүүрсний салбарын хувьд нийт **~31.3** сая.тныг 2017 олборлож үүнээс **~23** сая.тн-г экспортод гаргаж төсөвт **~226** тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тооцсон. БНХАУ-ын нүүрсний эрэлт нэмэгдсэнээс хамаарч 2016 оны эхний 9 сарын байдлаар **~16** сая.тн нүүрс экспортолсон ба оны эцэст **~22.3** сая.тн хүрэх төлөвтэй байна. Хэдий тоо хэмжээний хувьд биелэлт сайн боловч, борлуулж буй үнэ нь доогуур, ихэнх нүүрс нь Чалко-тай байгуулсан гэрээний төлбөрт суутгагдаж байна.
- Төсөлд зэсийн баяжмалын экспортын биет хэмжээг **~1,362** мян.тн байхаар тооцсон. 2016 оны эхний 9 сарын байдлаар **~1,205** мянган тонныг экспортолсон ба оны эцэст **~1,682** мян.тн-д хүрч төлөвлөсөн хэмжээнээс 23%-иар давж биелэхээр хүлээгдэж байна. 2017 төсөлд **~1,500** мян.тн ("Оюу толгой" ХХК **~850** мян.тн зэсийн баяжмал үйлдвэрлэн борлуулж, төсөвт нийт **~462** тэрбум төгрөгийн татвар, "Эрдэнэт үйлдвэр" ХХК нь **~650** мян.тн зэсийн баяжмал олборлож, төсөвт **~175.4** орчим тэрбум төгрөгийн татвар төвлөрүүлнэ) баяжмал экспортолж төсөвт **~638** тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тооцсон нь 2016 ХБГ-тэй харьцуулахад биет хэмжээний хувьд 11%-иар буурахаар байгаа боловч орлогын өөрчлөлтийн хувьд даруй 71%-иар нэмэгдэхээр байна. Тус өөрчлөлтийн шалтгаан нь үнийн болон биет хэмжээний өсөлтөөс бус харин Оюу Толгой төслийн газрын гүний уурхайн хөрөнгө оруулалтын ажил эхэлж татварын орлого нэмэгдэнэ гэж үзжээ.

ТӨСВИЙН ОРЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТИЙГ БОЛОВСРУУЛАХАД АШИГЛАСАН СУУРЬ ЗАРЧМУУДЫН ИХЭНХ НЬ ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ХҮНДРЭЛТЭЙ ӨНӨӨ ҮЕД ХЭРЭГЖИХ БОЛОМЖ БАГА, 2017 ОНД НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГОД ТАСАЛДАЛ ҮҮСЭХ ӨНДӨР ЭРСДЭЛТЭЙ

		САНГИЙН ЯАМ		ХӨНДЛӨНГИЙН ДҮГНЭЛТ
		Төлөвлөлтөд баримталсан суурь зарчмын үндэслэл, нөлөөлөл	Төвлөрөх орлогын дүн	Өнгөрсөн болон өнөөгийн бодит нөхцөл байдалд суурилан дүгнэх нь:
ИХ ХЭРЭГЖИХ БОЛОМЖ БАГА	Гол асуудал Борлуулалтын орлого нь 1.5 тэрбум төгрөгөөс ихгүй нэр бүхий салбаруудад ААНОАТ-г 1% болгох	Засгийн газрын 2016-2020 оны ү/ажиллагааны хөтөлбөрт тусгасан газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэл, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нэхмэлийн болон хувцас үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл багтсан	-	Хөдөлмөрийн бүтээмж, ажлын байр бий болгох гэсэн үндсэн шалгуураар салбаруудыг сонгох, татварын хөнгөлөлт үзүүлэх хэрэгтэй
	Шинээр татвар хураамж нэмэх, бий болгохгүй байх	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд шинээр татвар хураамж нэмэх, бий болгохгүй	-	ААНОАТ, ХХОАТ-н бааз суурь буурч буй энэ үед шинээр татвар нэмэх нь эдийн засгийн хүндрэлийг гүнзгийрүүлэх сөрөг нөлөөтэй
	НӨАТ-ын хэрэгжилтийг сайжруулах, татварын бааз суурийг нэмэгдүүлэх	Иргэдийн төлсөн татварын 20 хувийг нь буцаан олгох замаар бараа, ажил, үйлчилгээний борлуулалтыг бүртгэн татварын бааз суурийг тэлж, бүртгэлийн тогтолцоог сайжруулах	-	Хэрэгжүүлж арга механизмыг сайжруулах, ebarimt.mn болон бусад дагалдах үйлчилгээг олон улсын жишигт хүргэх
	Өмч хувьчлал, Ногдол ашгийг нэмэгдүүлэх	Төрийн өмчит ААН-г хувьчлах, алдагдалтай ажиллаж байгаа төрийн өмчит компаниудын менежментийг сайжруулж, ашигтай ажиллуулах бодлогыг баримтлан төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогыг нэмэгдүүлэх	~137 тэрбум төгрөг	2015, 2016 төсвийн төсөлд өмч хувьчлал хийгдэхээр төлөвлөсөн ч биелээгүй. Эрдэнэт үйлдвэрээс бусад т.өмчит ААН-с ногдол ашиг хуваарилах боломж хомс
	Томоохон төслүүдийг эрчимжүүлж бүтээн байгуулалтыг нэмэгдүүлнэ	“Оюу толгой” төслийн далд уурхай, “Таван толгой цахилгаан станц”, “ДЦС-3 өргөтгөл”, “Таван толгой”, “Гацуурт” төслүүдийг эрчимжүүлж, бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлтийг бий болгож, төсвийн орлогыг нэмэгдүүлэх	~250 тэрбум төгрөг	Зах зээлийн төлөв хандлага, улс төрийн шахалт зэрэг хүчин зүйлсээс ихээр шалтгаална. Цаг хугацааны эрсдэл өндөр
	Тогтворжуулалтын сан, ирээдүйн өв санд орлого төвлөрүүлэх	Зэсийн тэнцвэржүүлсэн үнэ, зах зээлийн үнийн зөрүүгээс үүсэх орлогыг Төсвийн тогтворжуулалтын санд, Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын 65 хувийг Ирээдүйн өв санд тус тус төвлөрүүлэх	~220 тэрбум төгрөг	БНХАУ-ын эдийн засгийн сааралт, дэлхийн түүхий эдийн зах зээл тодорхой бус байдал зэргээс шалтгаалан зэсийн үнэ өсөх магадлал муу, эрсдэл өндөр

ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙГ УЛ СУУРЬТАЙ ХИЙХ НЬ ТӨСВИЙН ОРЛОГЫГ БҮРДҮҮЛЭХ ХАМГИЙН ОНОВЧТОЙ АРГА

1 ТӨСӨӨЛӨЛ, БОДЛОГЫН УЯЛДАА, ИЛ ТОД БАЙДАЛ

- Жил бүр Монголбанкны өргөн барьдаг Мөнгөний бодлогын үндсэн чиглэл, Сангийн яамны нэгдсэн төсвийн төслүүдийн макро эдийн засгийн орчны төсөөллийн тоо мэдээлэл нь харилцан ялгаатай байдаг. Хэдийгээр ашигласан урдч нөхцөл, загварчлал, цаг хугацааны хүрээний ялгаатай байдлаас шалтгаалан зөрүүтэй байх боломжтой ч эдийн засгийн гол бодлого боловсруулагч байгууллагуудын хувьд харилцан уялдаатай байх нь чухал.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТААМАГЛАЛ.

	Бодит эдийн засгийн өсөлт %	Валютын ханш \$/₮	Инфляцийн өсөлт (YoY%)	Гадаад худалдааны эргэц (сая \$)
1.Сангийн яам	3.0%	2250	6.5%	7,214.90
2.Монголбанк	2.8%	NA	4.4%	NA
3.ОУВС	1.0%	NA	6.7%	NA
4.АХБ	1.4%	NA	5.4%	NA
Зөрүү (1-2)	0.2%		2.1%	
Дундаж	2.1%		5.8%	

Эх үүсвэр: ОУВС, АХБ, Дэлхийн банк, Монголбанк, Сангийн яам, Судлаачийн тооцоо

2 БОЛОВСРУУЛАЛТ, СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭ


- Тус уялдааг Санхүүгийн Тогтвортой Байдлын Албаар дамжуулан Монголбанк, Сангийн яамны тоон мэдээллийн хэрэглээ, таамаглал, тайлан боловсруулалтыг нягт уялдуулах шаардлагатай¹. Бодлого уялдуулах хүрээнд эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөрийг харилцан уялдаатай, хамтран хэрэгжүүлэх
- Сангийн яамны боловсруулсан 2017 оны нэгдсэн төсвийн баримт бичигт дараах нийтлэг дутагдлууд ажиглагдсан:
 - Танилцуулга баримт бичгийн боловсруулалт дутмаг, Орлого – Зарлагын төлөвлөлтийг нэгтгэн хянаж эцэслэн тулгаагүйн улмаар үг хэллэг, бичлэгийн стандарт ялгаатай, өгүүлбэрзүйн хувьд ойлгомжгүй
 - Тооцооллын зөрүүтэй байдал
 - Танилцуулга баримтын загвар, формат эмх цэгцгүй
 - Судалгааны эх үүсвэрийг дурдаагүй, товчилсон болон журамласан үг хэллэгийн тайлбар багтаагүй

ЗӨВЛӨМЖ

Төсвийн төлөвлөлтийг ул суурьтай хийх нь төсвийн орлогыг бүрдүүлэх хамгийн оновчтой арга юм.

1 2014 оны Монгол улсын нэгдсэн төсвийн төсөлд сангийн яам Бодит ДНБ-ний өсөлтийг Монголбанк-ны төсөөллөөс 9% илүү төсөөлж байсан.

2015, 2016 ОНЫ ТӨСӨЛД ХИЙСЭН ХӨНДЛӨНГИЙН ТОЙМ ДҮГНЭЛТИЙН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ ӨНӨӨГ ХҮРТЭЛ ХАНГАГДААГҮЙ БАЙГАА НЬ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ БИЙ БОЛГОХ ЧИГЛЭЛД **ТӨСӨВ** БОЛОН **МӨНГӨНИЙ БОДЛОГОД** ДОРВИТОЙ АХИЦ ГАРААГҮЙГ ИЛТГЭЖ БАЙНА.



2015, 2016 ОНЫ ТӨСӨЛД ХИЙСЭН ТОЙМ ДҮГНЭЛТҮҮД

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, МӨНГӨНИЙ БОДЛОГО, ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО ХӨТӨЛБӨРҮҮДЭД

Бодит ДНБ өсөлт 4 улирал, Суурь инфляци 6 улирал дараалан буурсан ч Монголбанкинд мөнгөний бодлогын хүүг бууруулж, зээлийн өсөлтийг тэтгэн эдийн засгийн өсөлтийг урамшуулах бодлогын орон зай байхгүй- **БОДЛОГЫН ДИЛЕММА** (МУ-ын 2016 оны Төсвийн төсөл)

Монголбанкны хэрэгжүүлсэн Үнэ тогтворжуулах, ипотекийн хөтөлбөрүүд
ДАВХАР ИРТЭЙ ТОНГОРОГ (МУ-ын 2015 оны Төсвийн төсөл)

Хөтөлбөрүүдийн хүрээнд эдийн засагт хэт их МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ хийсэн нь нэг талаас эерэг нөлөөтэй харагдавч нөгөө талаас валютын **ХАНШИЙН ЭРЭЛТИЙГ ОГЦОМ ХӨӨРӨГДӨЖ ДАВХАР ЭРСДЛИЙГ** бий болгосон. Өөрөөр хэлбэл Төвбанкны үйл ажиллагаа валютын ханшийг сулруулахад нөлөөлсөн. Монголбанкны **ҮНДСЭН ҮҮРЭГ АЛДАГДАЖ, САНГИЙН ЯАМ ШИГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЖҮҮЛСЭН** нь бодлогын алдаанд хүргэсэн байх магадлалтай.(МУ-ын 2015 оны Төсвийн төсөл)

ТӨСВИЙН АЛДАГДАЛ, САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР, ХӨГЖЛИЙН БАНК

Төсөвт тавих хяналтыг онцгой нэмэгдүүлэх, баталсан түвшнээс илүү алдагдал бий болгохыг зөвшөөрөхгүй байх, төсвийн зарцуулалтын үр ашиг, ил байдлыг онцгой шаардах хэрэгтэй (МУ-ын 2015 оны Төсвийн төсөл)

ТӨСВИЙН ХЯНАЛТ СУЛАРСНЫ УЛМААС ЖИЛ БҮР ТОДОТГОДОГ САХИЛГА БАТГҮЙ ТӨСВИЙН БОДЛОГОТой БОЛСОН (МУ-ын 2015 оны Төсвийн төсөл)

Төсвийн он дараалсан алдагдлууд **ХУВИЙН ХЭВШЛИЙН ӨСӨЛТӨД СӨРГӨӨР НӨЛӨӨЛСӨН ХӨГЖЛИЙН БАНК МӨСӨН УУЛ ШИГ...** Төсвийн гадуурх хяналтгүй санхүүжилт?, Эргэн төлөгдөх, эдийн засгийн ашиг бүхий төсөл санхүүжүүлэх боломж хомс?, **Хөгжлийн банкыг хянах вэ** Хууль эрхзүйн орчин бүрдсэн үү? (МУ-ын 2016 оны Төсвийн төсөл)

ГАДААД ВАЛЮТЫН ХАНШ, ВАЛЮТЫН НӨӨЦ

Монголбанк ~1.77 тэрбум ам.доллантай тэнцэх хэмжээний юаны своп хийсний дийлэнх хэсгийг төгрөгийн ханшийг тогтворжуулахад зарцуулсан (МУ-ын 2016 оны Төсвийн төсөл)

**ТӨГРӨГИЙН ХАНШИЙН СУЛРУУЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН СУУРЬ ШАЛТГААНЫГ ЗӨВӨӨР
ТАЙЛБАРЛАХЫН ОРОНД ТӨГРӨГИЙН ХАНШИЙГ ХҮЧЭЭР ТОГТООН БАРИХ БОДЛОГЫГ МОНГОЛБАНК
2011 ОНООС ХОЙШ ТОГТМОЛ ХЭРЭГЖҮҮЛСЭЭР ИРСЭН**

ТӨГРӨГИЙН ХАНШИЙГ БАРЬЖ ТОГТООН ААЖИМ СУЛРУУЛАХ БОДЛОГО нь маш муу бодлогын хувилбар биш боловч **ААЖМААР БУЦАЛЖ БУЙ ХАЛУУН УСАНД СУУЖ БУЙ МЭЛХИЙТЭЙ** адил юм.

Гадаад валютын нөөц шавхагдаж, **ОУВС, ДОНОР БАЙГУУЛЛАГУУДЫН** тулгалтаар мөнгөний бодлого хэрэгжих шаардлага тулгарна;

Зах зээлд **ДОЛЛАРЖИХ ҮЗЭГДЭЛ УЛАМ БҮР ГАЗАР АВЧ ТӨГРӨГТ ИТГЭХ ИТГЭЛ ҮЛЭМЖ ХЭМЖЭЭГЭЭР БУУРЧ**, хүлээлтийн гажуудал үүснэ: *(МУ-ын 2016 оны Төсвийн төсөл)*

ТӨСВИЙН ОРЛОГОД УЧИРСАН ГОЛЛОХ 5 ЭРСДЭЛ (2013 – 2016 ОН) 2017 ОНД УЧИРЧ БОЛЗОШГУЙ ГОЛЛОХ 5 ЭРСДЭЛ (БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ)

2013	2014	2015	2016	2017
Бусад татвар 1	Уул уурхайн бүтээгдэхүүний үнийг буруу төлөвлөснөөс үүдэлтэй эрсдэл 1	Уул уурхайн бүтээгдэхүүний үнийг буруу төлөвлөснөөс үүдэлтэй эрсдэл 1	Гадаад тусламж, хандиваас цуглах орлого 1	Оюу Толгой Гүний Уурхайн төслийг хэрэгжүүлэх, Таван Толгой төслийг урагшлуулах хөрөнгө оруулалт шийдвэрлэгдэхгүй байх 1
Уул уурхайн бүтээгдэхүүний биет хэмжээг буруу төлөвлөснөөс үүдэлтэй эрсдэл 2	Бусад татвар 2	Өмч хувьчлалын орлого 2	Өмч хувьчлалын орлого 2	Гадаад тусламж хандиваас цуглах орлого 2
НӨАТ орлогын бууралт 3	Оюу Толгой Гүний Уурхайн төслийг хэрэгжүүлэх, Таван Толгой төслийг урагшлуулах хөрөнгө оруулалтыг шийдвэрлэгдэхгүй байх 3	Оюу Толгой Гүний Уурхайн төслийг хэрэгжүүлэх, Таван Толгой төслийг урагшлуулах хөрөнгө оруулалтыг шийдвэрлэгдэхгүй байх 3	Оюу Толгой Гүний Уурхайн төслийг хэрэгжүүлэх, Таван Толгой төслийг урагшлуулах хөрөнгө оруулалт шийдвэрлэгдэхгүй байх 3	Өмч хувьчлалын орлого 3
Импортын гаалийн албан татвар 4	НӨАТ-ын орлогын бууралт 4	НӨАТ-ын орлогын бууралт 4	Алт, Мах Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээр Эдийн засагт нөлөөлөх 4	Уул уурхайн бүтээгдэхүүний биет хэмжээг буруу төлөвлөснөөс үүдэлтэй эрсдэл 4
Автобензин, дизель түлшний Онцгой албан татвар 5	Импортын гаалийн албан татвар 5	Импортын гаалийн албан татвар 5	НӨАТ-ын орлогын бууралт 5	НӨАТ-ын орлогын бууралт 5

- Эдийн засгийн идэвх бууралтаас үүссэн эрсдэл
- Томоохон хөтөлбөр, Төсөл хэрэгжээгүй улмаас үүссэн эрсдэл
- Татварын бус орлогын бусад татварын орлого буурсан эрсдэл
- Гадаад хандив, тусламж цагтаа орж ирээгүйтэй холботой эрсдэл

- Өмч хувьчлал, төрийн менежменттэй холбоотой эрсдэл
- Уул уурхайн орлоготой холбоотой эрсдэл
- Онцгой албан татварын орлого буурсан эрсдэл

УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ (ХУВИЛБАРААР)

ТООЦООЛОЛ

Эрсдэлүүд		Нэгж бууралт	Хувилбар 1: Нөхцөл байдал хэвээр үргэлжлэх	Хувилбар 2: Уул уурхайн зах зээлд уналт үргэлжлэх (төлөвлөгөө 70%)	Хувилбар 3: Өмнөх хувилбарууд зэрэг биелэх, хямрал
Гадаад: Уул уурхай, Хөрөнгө Оруулалт	Нүүрсний үнэ 5 ам.доллараар буурах	12	0	110	110
	Нүүрсний экспорт 1 сая тонноор буурах	4.5	0	20	20
	Зэсийн үнэ 100 ам.доллараар буурах	3.9	0	39	39
	Зэсийн баяжмалын хэмжээ 50,000 тонноор буурах	6.6	0	39	39
	Төлөвлөсөн уул уурхайн, дэд бүтцийн төслүүд саатах	250.9	251	-	251
Гадаад Нөхцөл байдал	Гадаад тусламжийн орлого төсөвт төвлөрөхгүй байх	50	50	50	50
	Импортын хэмжээ 100 сая ам.доллараар буурах	29.4	124	-	124
Менежмент	Өмч хувьчлалыг 2017 онд багтааж хийхгүй байх, он дамжих	127.3	127	-	127
НИЙТ БОЛЗОШГҮЙ АЛДАГДАЛ		473	552	258	761

ХАВСРАЛТ №1

Ирээдүйн өв сангийн тухай

“ИРЭЭДҮЙН ӨВ САН” 6 ЖИЛИЙН ХУГАЦААНД ТӨСӨВЛӨСӨН ОРЛОГОО ЦУГЛУУЛЖ УЛСЫН ТӨСӨВТ ТУШААСНЫ ДАРАА ХУРИМТЛАЛ ҮҮСГЭХ БОЛОМЖ БҮРДЭНЭ.

Монгол улсын ерөнхийлөгчийн санаачлагаар батлагдсан “Ирээдүйн Өв Сан” нь эрдэс баялагын орлогоос хойч үеийнхэндээ тодорхой хэсгийг нь өвлүүлэх үүрэгтэй бөгөөд хуучин “Хүний хөгжил сан” дээр хүлээгдэж буй гүйцэтгэлээр хуримтлагдсан нийт 981 тэрбум төгрөгийн өр төлбөрийг улсын төсөвт шилжүүлэх өглөгтэйгээр эхлэх юм. Доор тухайн сангийн 2017 оны төсвийн төсөлд төлөвлөснөөр тооцон сангийн мөнгөн урсгалыг гаргасан бөгөөд 2022 оноос Ирээдүйн өв сан нь 0 баланстай болж хуримтлал үүсгэх боломжтой болохоор байна.

ИРЭЭДҮЙН ӨВ САН	2017	2018	2019	2020	2021	2022
Сангийн орлогын эх үүсвэр	тэрбум ₮	тэрбум ₮	тэрбум ₮	тэрбум ₮	тэрбум ₮	тэрбум ₮
Ногдол ашиг	6.9	-	-	-	-	-
АМНАТ-ын 65%	201.2	213.3	226.1	226.1	226.1	226.1
Сангийн зарлага						
Улсын төсвийн шилжүүлэг	160	100	50	-	-	-
Хүний хөгжил сангийн өрийн төлбөр	48.2	113.2	176.1	226.1	226.1	191.3
Сангийн мөнгөн урсгал						

